

## ОРХОНЫ ТҮРЭГИЙН ДУРСГАЛУУДАД ТЭНГЭРИЙН ҮЗЭЛ ТУССАН НЬ

*М.Хурметхан\**

Эртний болон дундад эртний түрэгийн түүх-соёл нь дэлхийн соёл иргэншлийн бүрэлдэхүүн хэсэг билээ. Дундад эртний уугуул түрэгүүдийн бүтээн уламжлуулсан Орхоны түүх, хэлний дурсгал болон хот суурин, гэрэлт хөшөө зэрэг дурсгалууд нь тэдний оюуны болоод эдийн соёл, шашин шүтлэг, итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзлийг нь сэргээн төсөөлөх бололцоог олгож байна. Орхоны түрэг бичээсүүд, хаад, цэргийн нэрт жанжин нарт зориулан босгосон онгон тахилгын байгууламжийн туурь, гэрэлт хөшөө, тахиж байсан ариун уул, ус гэх мэт нь тэдний оюуны ертөнцөд тэнгэрийн үзэл ноёрхож байсаныг тод томруун харуулж байна. Орхоны түүх соёлын дурсгалууд орон зай, цаг хугацааны болон бүтээгч угсаатны оюун санааны цогцолбороор бүтээгдсэн зүйл бөгөөд тэнд хэл, оюуны ба эдийн соёл, зан заншил, итгэл үнэмшил, билэгдэл, хээ угалз, хүн, мал, амьтаны дүрс зэрэг нь тэдний ертөнцийг үзэх үзэл болох тэнгэрийн үзлээ бүх талаар тусган үзүүлсэн байна. Тухайлбал, эртний түрэгүүд өөрсдийнхөө нутаглах нутаг, байгуулах хөшөө дурсгалын байршлыг тэнгэрийн үзлийн дагуу сонгож байжээ. Тэнгэрээс удамтай, тэнгэрээс бүтээгдсэн өвөг дээдсийн нутаг “Өтүкений ой хөвч Хангайд улиран нутагшвал хамаг улст муу үгүй” хэмээн тэмдэглэжээ. Дурсгалын цогцолбор байгуулахад уулсын хормой, гол усны эрэг орчмыг сонгож байсныг Онгийн, Шивээт Улаан, Могойн Шинэ Ус, Тэрх, Тэсийн онгон тахилын байршил харуулж байна. Өөрөөр хэлбэл, нас эцэслэсэн эхэстээ зориулан ариун барыг /сүм/ барьж, тэр хүний өөрийн болон хатны гэрэлт хөшөөг байрлуулсан, тэдгээрийн сүнсээр дамжуулан Тэнгэрт мөргөн залбирдаг байв.

Монгол оронд Түрэгийн тахил тайлгын онгоны байгууламж олноор хадгалагдан үлдсэн бөгөөд тэдгээрт Хүйс толгой, Хараа, Идэр, Гэндэн булаг, Шивээт Улаан, Онгийн, Күлтегин, Хөшөө Цайдам, Билгэ хаан, Тоньюкук, Моюнчур, Кули Чурын зэрэг тахил тайлгын цогцолборыг эрдэмтэд судлан шинжилсээр байна

Хунтайз Күлтегиний онгон нь язгууртны ийм дурсгалын томоохон нь бөгөөд хэлбэр төрх, зохион байгуулалтын хувьд бусдыг нь бүрэн төлөөлж чаддаг билээ. Энэхүү цогцолборын хоймор хэсэг 10.4х10.8 м хэмжээтэй шүтээний сүмийг, шороо дагтаршуулан хийсэн тавцан дээр барьж, эргэн тойронд нь 67х31 м хэмжээтэй, 1,1 м зузаан тоосгон хэрмээр хүрээлэн гадна талаар нь усан татаал татсан байжээ. Хэрмийн доторхи бүх талбайг хөх тоосго дэвсэн бүрснээс гадна

\* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

барилгын шал мөн хөх тоосго байжээ. Барилгын хана, шал болон хэрмийг барихад өөр өөр хэмжээ, хэлбэртэй тоосго хэрэглэсэн ба малтлагын явцад дээврийн тосгуур, нүүр ваар, баганын чимэглэл зэрэг барилгын олон төрөл чимэг, ус гүйлгэх шатаасан шавар хоолой зэрэг зүйл гарчээ. Шүтээний сүмийн өмнөх талбайд Күлтегин жанжны амьдрал, тэмцлийг алдаршуулан бичсэн бичээс бүхий гэрэлт хөшөө асар том яст мэлхийн нуруунд суурилуулан босгоод түүнээс өмнө тийш шадар дагалт хүмүүсийн чулуун цоолбор хөргүүдийг үлдээж хэрмийн хаалга орчимд хоёр хонины чулуун дүрс тавиад тэдний дундаас наран мандах зүгийг чиглүүлэн 2300 м орчим зайд “балбал” хэмээх зэл чулууг цувруулан босгосон байснаас 173 үлдээд байжээ.

Энэхүү ариун тахилгын байгууламж нь өөрөө Тэнгэризмын үзэл санааг бүрэн тусгаж байгааг хэлэх хэрэгтэй. Гэрэлт хөшөөнд Сэрх буюу Янгирыг хажуугаас сийлсэн байдаг. Үүнд, Күлтегин, Алтан тамган дарханы хөшөөний дээд толгой болон бусад хэд хэдэн хаданд бий бөгөөд “Хаан төрийн билэг тэмдэг” юм. Мөн түрэгийн гэрэлт хөшөөг маш уран хийц бүхий мэлхий дүрстэй чулуунд суурилуулах, Күлтегиний хөшөөний орой ч эвхэрсэн хоёр луугаар чимэглэж, чулуун бодь гөрөөс, худ, эм хонь, арслан, бар, могой зэрэг баримал нь тэдний ертөнцийг үзэх үзлийг илэрхийлнэ.

Эр үндэсний тамга тэмдэг нь Тэнгэрийн илгээсэн элч болох “Сэрх” юм уу “Янгир”, /Сек-сек Ата нь-Цаг Хугацаа, Орон зайг /Unity/, эм үндэсний тамга тэмдэг нь “Хөх Шар” нь “Зенги-Баба болон Луу нь Үнэн, Ухаан Билиг, Тэвчээрийг /Truth/” дүрсэлсэн байна. Күлтегин, Билгэ хаан, Шивээт Улааны зэрэг онгон тахилгын байгууламжид худ, эм хонь, хурганы баримал хөшөө байдаг нь Хонины Дагин нь Шопан –Ата хэмээн үзэж, түүнийг гоо үзэсгэлэн, бодит үнэн, энэрэл хайр хийгээд сууг мэргэн ухааны билэг тэмдэг, дээд тэнгэрт хүрэх зам /Wisdom/, гарал үүслээ Гоо Маралаар урлан дүрсэлдэг байв. Күлтегины титэмийн цохон дээр далавчаа дэлгэн нисэхээр завдаж байгаа бүргэд /домгийн шувуу, гарьд гм/ сийлсэн нь “Хаан төрийн сүр хүчний билэг тэмдэг”, тэнгэрийн үзэлтэй шууд холбоотой билээ. Мөн Билгэ хааны алтан титэм ч үүнийг давхар баталж байна.

Эртний түрэгийн ариун тахилгын байгууламжуудыг харж хамгаалан, нилээд урт хугацаанд тасралтгүй мөргөлчид ирж, Тэнгэрт мөргөдөг байсан нь бидэнд уламжлагдан хүрэх гол нөхцлийг бүрдүүлжээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт явагдсан хээрийн судалгааны үр дүнд том болон бага түрэг бичээсийн дурсал 65, ариун тахилгын 12 байгууламжийн цогцолборын туурийн зураг хийгдэв. ТИКА-гаас эрхлэн явуулсан судалгааны үр дүнд Күлтегин, Билгэ хааны онгон тахилгын талаар бүрэн шинжлэх ухааны ойлголт бий болж, тэнгэрийн үзэл санаа тэдний ахуй амьдрал, улс төр, соёлын амьдралын бүхий хүрээг хамаарч байсан нь улам тодорхой болов. Тэд эдгээр ариун тахилгын

байгууламжийн цогцолборыг байгуулахдаа нөр их хүчин чармайлт гаргасан нь чухамдаа Агуу их Тэнгэр, Тэнгэр удамтай, Тэнгэрээс бүтээгдсэн эзэн хаандаа итгэж биширсэн тэнгэрийн үзлийн эрч хүч байлаа. Тухайлбал, Күлтегины цогцолборт гэхэд 100-аад км газраас 10-12 тонн суурь чулуу нэг ширхэг, 3-4 тонн мэлхий чулуу нэг ширхэг, 1-2 тонн онгоц чулуу нэг ширхэг, 15-18 тонн тахилгын чулуу нэг ширхэг, хүний дүрс баримал хийх чулуу 10 ширхэг, хонины баримал 2 ширхэгийг зөөн ирж, том цогцолборыг барьж байгуулжээ. Эртний түрэгүүд Тэнгэрт итгэн мөргөж, түүний ивээлд багтан, ирээдүйнхэнд үгээ үлдэх, сургаалиа айлдахын чухлыг ойлгосон нь тэнгэрийн үзлийн тусгал байлаа.

Эртний түрэгүүд Тэнгэр хамгийн дээд бурхан хийгээд Огторгуйн жингүй бүсэд оршдог, бүхэл бүтэн улс үндэстэний хувь заяа болон тэдний эзэн хаадыг удирдан явуулах чадвартай хэмээн үздэг байлаа. Энэ тухай Билгэ хааны хөшөөнд Тэнгэр бол мөнх харин хүний хөвгүүн үхэхээр төрдөг гэж бичжээ. Тэд тэнгэр өөд харж залбирал үйлддэг байв. Тэгээд ч “Түрэгийн Тэнгэр, дороос ариун дэлхий ус, Түрэг үл сөнөх болтугай. Өнөд орштугай хэмээн миний эцэг Элтэрэс хаан, эх Эльбилгэ хатан зулайгаас өргөн дэвшүүлэв” гэх зэргээр Тэнгэрийн хүч, дэмжлэг, ивээл хүртсэн тухайгаа болон Тэнгэрийн гэсгээлийн тухай гардаг билээ. Тэнгэр нь хаанд эрх мэдэл, мэргэн ухаан бэлэглэж, тэгээд хаан Тэнгэрээс удамтай, тэнгэрлэг болох жамтай гэж үздэг байсан ажээ. Түрэгүүд хоёр үндэс хэмээх суурь ойлголтын хүрээнд Тэнгэр бол эцэг, Дэлхий бол Эх хэмээн үздэг байжээ. Тэнгэр цор ганц бурхан бөгөөд хүн, амьд ба амьгүй байгалийг бүтээгч хүч хэмээн үздэг байна. Харин Тэнгэр нь Орчлонт Ертөнцийг–Йер Суб, Умай, Нар, Сар, Од, Агаар, Үүл, Салхи зэрэг 17 бурхадаар дамжуулан захирдаг хэмээн сэтгэдэг байв.

Эртний түрэгүүдийн ойлголтоор дорно зүгийг хөх, өмнө зүгийг улаан /хар хүрэн/, баруун зүгийг цагаан, хойд зүгийг хар, төвийг шар өнгөөр дүрсэлдэг байв. Агуу их хүчирхэг Тэнгэрийг Огторгуйд оршин суудаг хэмээн ойлгож, түүнийг хөх өнгөөр тэмдэглэдэг байв. Тэгээд түрэгүүд огторгуйд байгаа хэмээн төсөөлж байгаа Агуу их Тэнгэр бурханыг шүтэж байсанаас биш Хөх Тэнгэр /Небо юмуу Sky/-ийг шүтэж байсан хэрэг биш бололтой. Энэ нь бүх судлаачид Tenri хэмээх үгийн утгыг бүрэн сайн ойлгож чадаагүй болон хөх хэмээх үгийг анхаарснаас шалтгаалсан бололтой. Күлтегиний хөшөөний “Tenri teg tenride jaratmye Тырк билге kagan” гэсэн өгүүлбэрийг “тэнгэр шиг, тэнгэрээс ивээлт” хэмээн орчуулсанаар Тэнгэр нь Хөх Тэнгэр /Небо, Sky/ болж ойлгогджээ. Гэтэл тэр өгүүлбэр нь “Тэнгэрээс удамтай, Тэнгэр бүтээсэн” өөрөөр хэлбэл “гэрэлээс бүтээгдсэн”-тэй ижил утгатай юм. Тэдний ертөнцийг үзэх үзэл нь Ертөнцийн нэгдмэл чанарт үндэслэгджээ. Ертөнц эр ба эм удмаас бүрдэнэ хэмээн үзэж, эр удмын тэнгэр дэх билэгдэл нь Нар, эм удмынх Сар, Дэлхий дэх эр удмын билэгдэл Уул,

эм удмын билэгдэл Ус, эдгээрийн дээр Тэнгэр, тэр нь бүтээгч цорын ганц хүч хэмээн итгэдэг байв. Хоёр үндэсийн ойлголтоор ашина овог нь эцгийн тал, ашида эхийн талын овог юм. Төрийн системд нь төлөс ба тардуш /баруун ба зүүн жигүүр/, удирдлагад явгу ба шад, ёс суртахууны хэм хэмжээнд бөд ба умай, хөгжимд хоёр чавхдас, яруу найрагт шүлэгийн хос холболт, зурагт эр, эмийн билэгдэл, яриан болон бичиг үсэг дэх сингармонизм, консонантизм гэх мэт байгалийн зохицол, хэмнэлд үндэлэгдсэн үзэл болох нь харагдаж байна. Түрэгүүдэд хөх өнгө өсөж үржихийн билэгдэл, улаан-боловсрох, цагаан-гүйцэт боловсрох, хар-нөгөө ертөнцийн билэг тэмдэг байжээ. Энэхүү түрэгийн ертөнцийг танин мэдэх үзлийг энгийн иргэнээс эзэн хаад хүртэл өдөр тутмын амьдралдаа баримталдаг байжээ. Тэд орчлон ертөнцийг “дөрвөн өнцөг”-тэй гэж ойлгон, дөрвөн зүгийн билэгдэл тогтоож, хойд зүг хар өнгө нь нөгөө ертөнцтэй холбоотой үйл хөдлөл, зан үйлд зориулдаг бол дорно, өрнө, өмнө зүгийг амьдрал ахуйд холбогдох үйл хөдлөл, зан үйлд зориулагддаг байжээ.

Монгол Улсад эртний Түрэгийн үеийн тэнгэрийн үзэл санааг тод тусгасан гэрэлт хөшөө, онгон тахилын цогцолборыг судлах, хадгалах, хамгаалах, сэргээн босгох, алдаршуулан сурталчилах талаар Монгол Улсын Засгийн газрын зүгээс бололцооны хэрээр (ОХУ, Турк, ХБНГУ, Япон, БНХАУ, БНКАЗУ-тай хамтран) холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэхдээ, олон мянган соёлын дурсгалыг судлах, хадгалан хамгаалахад санхүүгийн болон эрдэм шинжилгээ судалгааны бололцоо тэр бүр хүрэлцээтэй биш байна. Эртний дурсгалуудыг барилгын материалд ашиглах, байраас нь хөдөлгөх, хулгайлах, эвдэн сүйтгэж байна. “Хар археологчид” олон болж, археологийн зарим судалгаа ч гэсэн шинжлэх ухааны зохих түвшинд хийгдэхгүй байна. Төр, засгийн зүгээс эдгээр зохисгүй зүйлийг таслан зогсох арга хэмжээ авч байгаа боловч хяналтанд бүрэн авч чадахгүй байгааг хэлэх хэрэгтэй юм.

Күлтегин, Билгэ хаан, Тоныкукийн дурсгалын цогцолборыг хадгалан хамгаалах, сэргээн босгох талаар зарим ажил хийгдэв. Гэхдээ хийвэл зохих ажлууд байсаар байна. Энэ нь эртний дурсгал, алдарт хүмүүсийг алдаршуулан сурталчилах явдал юм. Тухайлбал, тэд амьдран аж төрж, их хэргийг бүтээж байсан эх нутагт нь Күлтегин, Билгэ хаан, Тоныкукийн нарын нэрээр нэрлэгдсэн хот, суурин, гудамж талбай гэх мэт байхгүй байсаар байгаа юм. Мөн мянган мянган дурсгалууд хээр хөдөө анхаарлын гадна үлдсэн хэвээр байна. Иймд эдгээр соёлын дурсгалыг судлах, хамгаалах, сэргээн босгох, алдаршуулан сурталчилахад зориулагдсан шинжлэх ухааны урт хугацааны төсөл хөтөлбөрийг боловсруулан хамтын хүчээр хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Евразийн их хээр талын нүүдлийн соёл иргэншлийн үнэт өвийг хайрлан хамгаалах нь бидний оюуны соёлын стратеги, үндэсний соёлын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, баталгаа байх ёстой билээ.

Энэ бүхнээс үзэхэд Хөх Түрэгийн тэнгэрийн үзэл нь тухайн цаг үедээ өндөр хөгжсөн нь тодорхой харагдах бөгөөд түүнийг батлах чамгүй зүйл бидний үед уламжлагдан хүрч, олон үеийн эрдэмтэдийн хүч хөдөлмөрөөр судлагдсан ба судлагдсаар байна.

### **Ном зүй**

1. Мырзатай Жодасбеков, Каржаубай Сарткожаулы. Атлас Орхонских Памятников Күлтегин. 2006
2. Khurmetkhan M, Burkitjan Kh. Anthology of Orkhon Turkic Inscriptions. Ulaanbaatar 2006
3. Rafael Bezertinov. Tengrianizm-religion of Turks and Mongols. Naberezhnye Chelny, 2000 Chapter III Deities. pp.71-95
4. Album of the Turkish Monuments in Mongolia. A., 2001.  
Work For The Turkish Monuments In Mongolia In Year 2000 (257 p). Ankara 2002.  
Work For The Turkish Monuments In Mongolia In Year 2001. (487 p). Ankara 2003.  
Work For The Turkish Monuments In Mongolia In Year 2002. Ankara 2004.  
The Project of The Turkish Monuments In Mongolia, 2003 Studies. Ankara 2005
5. <http://irq.kaznpu.kz>